ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2025 оны 4 сарын 30-ны өдөр
Цаг: 10:00
Хэлбэр: Танхим
Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. "Ногдол ашиг хуваарилах тухай" ТУЗ тогтоолыг танилцуулах;
4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
5. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;
6. Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
8. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;
9. Бусад

Хурлын дарга Ч.Чинзориг: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хурлын тооллогын комиссыг танилцуулъя. Тооллогын комиссын даргаар В.Шинэбаяр, гишүүдээр Ж.Батбилэг, Т.Батчимэг нар томилогдон ажиллаж байна.

Одоо та бүхэнд хурлын ирцийг тооллогын комиссын дарга В.Шинэбаяр танилцуулна.

В.Шинэбаяр: Өглөөний мэнд. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 2,000,000,000 ширхэг хувьцаанаас тус өдрийн хуралд 1,695,007,160 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 84.75% болж ирц бүрдсэн байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн байна.

Хурлын дарга Ч.Чинзориг: тооллоыгн комиссын дарга Шинэбаярт баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдэе. Та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя.

1	Бүртгэлийн үйл ажиллагаа	10 минут	Тооллогын комисс
2	Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	5 минут	Хурлын дарга
3	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;	5 минут	Аудитын хорооны дарга
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын "Ногдол ашиг хуваарилах тухай" 3 тоот тогтоолыг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
6	Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;	10 минут	Хурлын дарга
7	ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;	10 минут	Хурлын дарга

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК 9025010057 2013816 СБТ27226

8	Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;	15 минут	Хурлын дарга
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;	10 минут	Хурлын дарга
10	Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;	5 минут	Хурлын дарга
11	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	20 минут	Хурлын дарга
12	Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
13	Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	30 минут	Тооллогын комисс
14	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут	Хурлын дарга

Та бүхэнд хурлын дэгийг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулъя:

Хурлын дарга Ч.Чинзориг: Манай компани нь Монголын хөрөнгийн бирж дээр 2-р ангилалд эрэмблэгдэж байна. 1-р ангилал руу орох шаардлагыг хангаж байгаа боловч хувьцааны хөрвөх чадвар мөн түүнчлэн идэвхтэй арилжаа хийгдэхгүй байгаа хүчин зүйлээс болж 1-р ангилал руу хараахан ороогүй байгаа. Ирээдүйд SPO хийж хувьцааныхаа хөрвөх чадварыг сайжруулах бодолтой байгаа.

2024 онд компанийн Монголын хөрөнгийн бирж дээрх үсгэн код буюу VIK симбол нэрийг сольж TAND болгон өөрчлөсөн. Компани 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 1359 харилцагчтай, Зээлийн багц маань өмнө жил хөрөнгө нэмснээс хойш өсөөд 27,949,560,011.48 төгрөг болж, үйл ажиллагааны 3 төрөл, 9 бүтээгдэхүүн үйлчилгээ, 14 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 950 хүрсэн байна. Өнгөрсөн онд хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гарган 489,000 ширхэг хувьцааг гаргаснаар нийт гаргасан хувьцааны тоо 2,000,000,000 ширхэг болж нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 4,600,000,000 болж нэмэгдсэн байна.

Өнгөрсөн жилийн үйл ажиллагаанд зээлийн багц нь авто машины зах зээл дээр төвлөрсөн байдалтай нийт зээлийн 73.5%-ыг эзэлж бусад зээл буюу Бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл болон Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, мөн бусад гэсэн зээл нь 26.5%-ыг эзэлж байна. Нийт зээлийн 4.8% нь хугацаа хэтрэлттэй, 7.2% нь чанаргүй зээл, 88% -ийг хэвийн зээл эзлэж байна. Бид энэхүү хугацаа хэтрэлттэй чанаргүй гэсэн зээлийн хувь хэмжээг багасгах тал дээл төвлөрч ажиллана. Манай компанийн зээлийн багц нь өнгөрсөн жил дүрмийн сандаа нэмэлт өөрчлөлт хийсэнтэй уялдаатайгаар 30%-иар эрс өссөн байна. Олгосон зээлийн хувьд өнгөрсөн жилийн хувьд 24.5 тэрбум буюу 45%-ийн өсөлттэй харин олгосон зээлийн тоо нь 769 буюу 16% -иар өссөн үзүүлэлттэй байна. Өгөөжийн үзүүлэлт нь эргэлтийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой өгөөжийн хувь болон цэвэр ашгийн хувь 55.2% болж буурсан байна. Компанийн хөрөнгө Ш.Такаёши гэх том хувьцаа эзэмшигч орж ирснээс хойш 3 жил тогтмол нэмэгдэж өсөлттэй байгаа. 100 сая, 300 сая, 400 сая иений хөрөнгө оруулалтын 3 жил дараалан татсанаараа компанийн хөрөнгө нь Итгэлцлийн 5.3 тэрбумыг оролцуулаад 31 тэрбумын хөрөнгөтэй болсон. Нийт хөрөнгөөс 25.6 тэрбум нь өөрийн хөрөнгө юм. Өнгөрсөн жилийн ашиг 10%-иар өсөж 3.7 тэрбум болсон ч манайх илүү өсөлттэй байх боломжтой байсан гэж үзэж байгаа.

Компанийн ажилчидынхаа өсөж дэвших боломжыг харгалзан үзэж нийтдээ 2 ажилтанд 100% сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүсэн байна. Мөн ажилтнуудынхаа эрх зүйн боловрсол мэдлэгийг нэмэх үүднээс хуулийн фирмтэй хамтран сургалт зохион байгуулсан. Мөн урлаг спортын үйл ажиллагааг ч мөн адил компанийн зүгээс дэмжлэг үзүүлдэг. Энэ хүрээд үйл ажиллагааны тайлан дуусаж байна.

Хурлын дарга Ч.Чинзориг: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Энх- Амгалан аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна.



Б.Энх-Амгалан: Сайн байцгаана уу хувьцаа эзэмшигчдээ. Тайлант хугацаанд Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа.

Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Компани 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Шинэ их Тэрбум Аудит ХХК-ийг хөндлөнгийн аудитын компаниар сонгон ажилласан. Компанийн үйл ажиллагаанд аудит хийсэн компанийн зүгээс Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тайланг үнэн зөв бодитой илэрхийлсэн гэж дүгнэсэн байна. Компани нь 2024 онд 6 тэрбум 149 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 12.8 хувиар өссөн бөгөөд хуримтлагдсан ашиг оны эцэст 3.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 12.1 хувиар өссөн дүн юм. Эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайжирсан, иргэдийн дундаж орлого өссөн болон компанийн үйл ажиллагаа идэвхэжсэн нь зээл олголт нэмэгдэж эцсийн дүндээ цэвэр ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

Олгосон зээлийн зардал	2,4491 сая төгрөг
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	2,058 сая төгрөг
Цалин -	216.7 сая төгрөг
Ашиглалтын зардал	40.3 сая төгрөг
Татвар, нийгмийн даатгалд төлсөн	1,094.8 сая төгрөг
Бусад зардал	331.7 сая төгрөг

Гарч байгаа нийт хүүгийн бус зардал 1.19 тэрбум төгрөг бөгөөд үүний 38 хувь нь цалингийн зардал байна. 2024 онд компанийн зардал өсөлттэй байсан ч үндсэн үйл ажиллагааны мөнгөн болон мөнгөн бус орлого өсөлттэй гарсан нь компанийн үйл ажиллагааашигтай гарахад нөлөөлжээ.

Орлогын албан татварын талаар:

Компанийн зүгээс орлогын албан татварт 2023 онд 373.3 сая төгрөг төлж байсан бол 2024 онд 423.7 сая төгрөг болж 13.5 хувиар өссөн байна.

Санхүүгийн өр төлбөрийн талаар:

Тайлант хугацаанд бусдаас авсан урт болон богино хугацааны өр төлбөрийн дүнг харвал санхүүгийн өр төлбөр 5 тэрбум, санхүүгийн бус өр төлбөр 313.5 сая төгрөг байна. Нийт дүнгээр авч үзвэл 5.4 тэрбум төгрөгийн өртэй бөгөөд өмнөх 2023 онтой харьцуулахад 90 орчим сая төгрөгөөр буурсан байна.

Эрсдэлийн сангийн талаар:

СЗХ-оос баталсан журмын дагуу эрсдэлийн сангийн хувь хэмжээ, тодорхойлон зээлийн эрсдэлийн санг тооцож ажиллажээ.

Энд хугацаа хэтэрсэн зээл 66 сая, хэвийн бус зээл 218 сая, Эргэлзээтэй зээл 306 сая, Муу зээл 557 сая байхаар эрсдэлийн сангаа тодорхойлсон байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 749 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 216 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Биет бус хөрөнгийн хувьд Санхүүгийн үйл ажиллагааны Интерактив Би Ай ХХК-ийн Спинел 6.0 программыг ашиглаж байгаа бөгөөд оны эцсийн байдлаар үлдэгдэл өртөг 2.4 сая төгрөг байна.

Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:



Компанийн 2024 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Хурлын дарга Ч.Чинзориг: За та бүхэнд **<u>хэлэлцэх асуудал 3</u>** буюу Ногдол ашиг хуваарилах тухай компанийн ТУЗ-өөс гарсан тогтоолыг танилцуулъя.

Компанийн ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 9-ний өдрийн 03 тоот тогтоолоор 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашиг болох 3,705,620,626.44 төгрөгөөс компанийн хувьцаа эзэмшигчдэд 2,200,000,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилхаар тогтоосон бөгөөд нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.10 /*нэг төгрөг арван мөнгө*/ төгрөгөөр тогтоосон байна.

Өнгөрсөн оныхоос ноогдол ашиг буурч байгаа ч компанийн дүрмийн санг 1.4 тэрбумаар нэмэгдүүлж нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 6,040,000,000 болж нэмэгдэж байгаа юм. Хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх болсон шалтгаан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 2-р сарын 25-ны өдрийн 70 дугаар тоот тогтоолоор Итгэлцэлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарь гарсан. Тус тогтоолын дагуу 2026 оны 4-р сарын 10-ны өдрийн байдлаар 5,000,000,0000 болгох шаардлага гарсан тул компани 2024 оны цэвэр ашгаасаа нэмэгдүүлсэх болсон.

<u>Хэлэлцэх асуудал 4:</u> Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай.

Хурлын дарга Ч.Чинзориг: Хэлэлцэх асуудал 3 дээр танилцуулсанчлан 1.4 тэрбумаар дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх талаар саналаа өгнө үү.

<u>Хэлэлцэх асуудал 5:</u> ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;

Хурлын дарга Ч.Чинзориг: 2022 онд ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар сонгосон бөгөөд энэ онд бүрэн эрх дуусгавар болж байгаа юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвших хүн хараахан байгаагүй учраас өнөөдрийн хурлаар өмнөх ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр үргэлжлүүлэх талаар та бүхнээс кумулятив саналын хуудсаараа санал авах юм.

<u>Хэлэлцэх асуудал 6:</u> Өрийн бичиг гаргах

Хурлын дарга Ч.Чинзориг: Дараагийн асуудалд өрийн бичиг гаргах асуудал оруулсан байгаа. Компани бизнесийн цар хүрээгээ тэлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй болон хаалттай бонд мөн OTC дээр мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт бонд гаргах шаардлагатай байна. Компани нь хөрөнгийн зохистой харьцааны хувьд нийт 12 тэрбум төгрөгийн бонд гаргах боломжтой байгаа. Хувьцаат компанийн хувьд санхүү, хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө татаж, идэвхитэй үйл ажиллагаа явуулах нь компанийн нэр хүндэд сайнаар нөлөөлнө гэж бодож байна. Гэхдээ сүүлийн үед хөрөнгө татах өртөг нэмэгдэж байгаа учир сайтар тооцоолж компанид ашигтай, эрсдэл бага хэлбэрээр гаргах шаардлагатай байгаа. Тийм учраас тухай бүрт холбогдох шаардлагатай шийдвэрүүдийг цаг алдалгүй гаргах эрхийг ТУЗ-д олгох талаар та бүхэн саналын хуудсаараа дамжуулан саналаа өгнө үү.

<u>Хэлэлцэх асуудал 7:</u> ТУЗ-ийн төсөв батлах

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК 9025010057 2013316 СБТ27226

Хурлын дарга Ч.Чинзориг: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн задаргааг хурлын материалд оруулсан байгаа. Төсвийн хувьд өмнөх жилээс нэмэгдээгүй хэвээр байгаа. Та бүхэн танилцаад саналын хуудсаараа саналаа өгнө үү.

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	1,500,000	18,000,000
2	Цалин /гишүүд/	8	1,000,000	96,000,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	900,000	10,800,000
4	ТУЗ ээлжит хурлын зардал	4	2,000,000	8,000,000
5	ТУЗ ээлжит бус хурлын зардал	6	1,500,000	9,000,000
6	ТУЗ-н бичиг хэрэг			10,000,000
7	ТУЗ-ын томилолт			50,000,000
Нийт дүн				201,800,000

Хэлэлцэх асуудал 8: Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай

<table>
<tr><td colspan="3">Харьцуулалтууд</td></tr>
<tr><td>Хуучин</td><td>Шинэчилсэн</td><td>Тэмдэглэл</td></tr>
<tr><td>6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 4,600,000,000 /Дөрвөн тэрбум зургаан зуун сая зургаан зуун төгрөг/ төгрөг байна.</td><td>6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 6,040,000,000 /зургаан тэрбум дөчин сая/ төгрөг байна.</td><td>Шинэчилсэн</td></tr>
<tr><td>6.2
<table>
<tr><td>Компанийн хувьцаа</td><td colspan="2">Тоо ширхэг</td><td>Хувьцааны төрөл</td></tr>
<tr><td rowspan="2">Зарласан хувьцаа</td><td rowspan="2">Нийт 6,003,866,050 ширхэг</td><td>Энгийн эрхийн 5,000,000,000 ширхэг</td><td>Энгийн эрхийн</td></tr>
<tr><td>Давуу эрхийн 1,003,866,050 ширхэг</td><td>Давуу эрхийн</td></tr>
<tr><td>Гаргасан хувьцаа</td><td colspan="2">Нийт 2,000,000,000 ширхэг</td><td>Энгийн эрхийн</td></tr>
</table></td><td>6.2
<table>
<tr><td>Компанийн хувьцаа</td><td colspan="2">Тоо ширхэг</td><td>Хувьцааны төрөл</td></tr>
<tr><td rowspan="2">Зарласан хувьцаа</td><td rowspan="2">Нийт 6,003,866,050 ширхэг</td><td>Энгийн эрхийн 5,000,000,000 ширхэг</td><td>Энгийн эрхийн</td></tr>
<tr><td>Давуу эрхийн 1,003,866,050 ширхэг</td><td>Давуу эрхийн</td></tr>
<tr><td>Гаргасан хувьцаа</td><td colspan="2">Нийт 2,000,000,000 ширхэг</td><td>Энгийн эрхийн</td></tr>
</table></td><td>Шинэчилсэн</td></tr>
<tr><td>6.2.1 Компани нь нийт 6,003,866,050 ширхэг зарласан хувьцаатай. Үүнээс нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000,000,000 /таван тэрбум/ ширхэг зарласан энгийн хувьцаатай, нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,003,866,050 ширхэг зарласан давуу эрхийн хувьцаатай байна.</td><td>6.2.1 Компани нь нийт 6,003,866,050 ширхэг зарласан хувьцаатай. Үүнээс нэг бүр нь 3.02 /гурван төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000,000,000 /таван тэрбум/ ширхэг зарласан энгийн хувьцаатай, нэг бүр нь 3.02 /гурван төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,003,866,050 ширхэг зарласан давуу эрхийн хувьцаатай байна.</td><td>Шинэчилсэн</td></tr>
<tr><td>6.2.2 Компани нэг бүр нь 2.3 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /Хоёр тэрбум / ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.</td><td>6.2.2 Компани нэг бүр нь 3.02 /гурван төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /Хоёр тэрбум / ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.</td><td>Шинэчилсэн</td></tr>
</table>

Хурлын дарга Ч.Чинзориг: Компани 2024 оны цэвэр ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж байгаатай холбогдон компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаа юм. Компанийн гаргасан хувьцаанд өөрчлөлт орохгүйгээр нэрлэсэн үнэ 2.3/ *хоёр төгрөг гурван мөнгө/* төгрөгөөс 3.02 */гурван төгрөг хоёр мөнгө/* болж нэмэгдснээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6,040,000,000 төгрөг болж өөрчлөгдөж байгаа юм.

Үүгээр өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусч байна. Та бүхэнд асуудлуудтай холбоотой асуулт байна уу.

Асуух асуулт байхгүй байвал саналын хуудсаараа саналаа өгнө үү.

Тооллогын комиссын дарга В.Шинэбаяр: Тооллогын комиссын дүн гарч дууслаа.

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар зөвшөөрсөн,
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар зөвшөөрсөн,
3. Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар зөвшөөрсөн,
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан А.Даваазориг, Б.Энх-Амгалан, Ч.Лодойравсал нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Ч.Чинзориг, П.Чинзориг, Ч.Тэмүдэр, Л.Очирмаа, Ч.Бадмааараг, Ц.Билэг-Өрнөх нар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдсон,
5. Өрийн бичиг гаргах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар зөвшөөрсөн,
6. 2024 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар зөвшөөрсөн,
7. Компанийн дүрмийн өөрчлөлтүүдийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.75% саналаар тус тус зөвшөөрсөн санал өгсөн байна.

Тогтоолын төслийг танилцуулаад батлаад явъя гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 7 тогтоол баталлаа.

Хурал хаасныг мэдэгдье: 11:25 минут

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: /Б.Бадамцэцэг/

Хурлын дарга: /Ч.Чинзориг/